

## **“БӨХӨГ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ**

2026 оны 04-р сарын 28-ны өдөр

Улаанбаатар хот

Монгол улсын компанийн тухай хуулийн 62-р зүйлийн 62.1, 69-р зүйлийн 69.1 дэх заалт болон “Бөхөг” ХК-ийн дүрмийн 7 дугаар зүйлийн 7.А хэсгийн заалтуудыг тус тус удирдлага болгон Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зарлан хуралдуулах тухай ТУЗ-ын тогтоолын дагуу “Бөхөг” ХК-ийн 2026 оны хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2026 оны 04-р сарын 28-ны өдрийн 10 цаг 00 минутанд Хан-Уул дүүргийн 13-р хорооны нутаг дэвсгэрт байрлах “Бөхөг” ХК-ийн байрны хурлын танхимд эхлэв.

Хуралд бүртгэлийн өдөр бүртгүүлсэн хувьцаа эзэмшигчид болох Ц.Чанцал, Ц.Ганцэцэг, Тооллогын комиссын гишүүд болох Л.Баттөр, Б.Мөнх-Оргил, М.Билгүүнзаяа, ТУЗ-ийн Нарийн бичгийн дарга Ж.Энхбат нар оролцов.

2026 оны хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг компанийн ТУЗ-ийн дарга А.Төмөр-Очир даргалав.

**Хурлын дарга А.Төмөр-Очир:** Юуны өмнө Монгол улсын компанийн тухай хуулинд заасны дагуу зарласан Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралдаа хүрэлцэн ирсэн хувьцаа эзэмшигчид та бүхэндээ энэ өдрийн мэндийг хүргэе. Өнөөдрийн хуралд компанийн нийт энгийн хувьцааны 302213 ширхэг хувьцааг эзэмшигч Ц.Чанцал, 119210 ширхэг хувьцааг эзэмшигч Ц.Ганцэцэг нар оролцож хурлын ирц 92,16 хувьтай байна. Иймээс 2025 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал /цаашид “ХЭХ” гэх/-ыг хуралдуулж байна. Миний бие ТУЗ-ийн Тогтоолын дагуу Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын даргаар томилогдсон учир хурлын үйл ажиллагааг удирдаж байгаа болно. Өнөөдрийн хурлаар бид дараахь асуудлыг хэлэлцэхээр оруулж ирж байна. Энэ талаар Хурлын зар гаргахдаа нийт хувьцаа эзэмшигчдэдээ мэдээллэсэн болно.

Үүнд:

1. Компанийн 2025 оны жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаархи ТУЗ-ийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэж батлах,
2. Компанийн 2026 оны үйл ажиллагааны болон бизнес төлөвлөгөөг батлах,
3. Их хэмжээний хэлцэл хийх, хувьцаа нэмж гаргах асуудлыг шийдвэрлэж ТУЗ-д эрх олгох эсэх,
4. ТУЗ-ийн ногдол ашиг тараах эсэх талаар гаргасан тогтоолыг хэлэлцэж батлах гэсэн асуудлууд багтаж байна.

Мэдээлэл сонссоны дараа асуулт, хариулт, саналаа хэлээд батлаад явна. Хурлын эхэнд компанийн хувьцаа эзэмшигч, гүйцэтгэх захирал Ц.Ганцэцэг 2025 оны үйл ажиллагааны талаар товч тайлан мэдээлэл өгнө.

**Хувьцаа эзэмшигч, Гүйцэтгэх захирал Ц.Ганцэцэг:**

Эрхэм хувьцаа эзэмшигч та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэж, эрүүл энх сайн сайхныг хүсье.

2025 оны үйл ажиллагааны тайланг та бүхэндээ товч танилцуулъя. Өнгөрсөн онд төлөвлөсөн хөрөнгө оруулалт болон зээл авах асуудлууд хэрэгжээгүй тул

төлөвлөсөн үйл ажиллагааны болон бизнес төлөвлөгөөнүүд хэрэгжиж чадсангүй. 2025 онд компанийн одоогийн нөөц бололцоонд тулгуурлан дараах ажлуудыг хийж гүйцэтгэлээ.

- Шувууны аж ахуйн компанийн олон улсын жишгийг судлан, мөн Монголд шувууны аж ахуйн чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй компаниудын үйл ажиллагааг судлан өөрийн компанийн бүтэц зохион байгуулалт болон жишиг хэлбэрийг тоймлон гаргаж, ТУЗ-д танилцууллаа.

- Дотоодын банк санхүүгийн байгууллагуудтай уулзаж урт хугацаат зээлийн талаар судалгаа гаргалаа.

- Харуул солигдсон тул тооллогын комиссыг 5 хүний бүрэлдэхүүнтэй байгуулж, шинээр томилогдсон харуул Н.Гармаад тооллогоор хашаа, барилга байгууламж, тоног төхөөрөмж, эд хөрөнгийг өнөөгийн байдлаар нь хүлээлгэн өгч, хөдөлмөрийн гэрээ, хариуцлагын гэрээ, нууц хадгалах гэрээг байгуулсан.

- Хашаан доторх их цэвэрлэгээг сар тутамд хийж хогийг ХУД-ийн ТҮК-д ачуулсан.

- Хан-Уул дүүргийн татварын хэлтсийн байцаагч, албаны даргатай уулзалт зохион байгуулж, олон жил хуримтлагдсан татварын өр төлбөрийн талаар, хэрхэн барагдуулах боломжтой талаар ярилцаж, тайлбар мэдэгдэл хүргүүлээ

- Мөн татварын хэлтсийн байцаагчтай зөвлөлдөн хуримтлагдсан Хувь хүний орлогын албан татварын өр болон автын татварыг бүрэн төлж барагдууллаа

- УБЦТС-д хуримтлагдсан өмнөх үеийн цахилгааны төлбөрөөс график гарган, сар бүр тодорхой хэмжээгээр төлж барагдуулж байна

- Өмнөх жилүүдэд байгуулсан гэрээний үндсэн дээр Мобиком, Юнител, Жи мобайл зэрэг үүрэн холбооны компаниудын сүлжээний сайтын түрээсийг үргэлжлүүлж, олсон орлогоор үйл ажиллагааны зардал, харуул хамгаалалтын ажилтны цалин, нийгмийн даатгалын зардлыг санхүүжүүлсэн.

- Санхүү бүртгэлийн үйл ажиллагааг зохих хууль, дүрэм, журмын дагуу баримт бичгийг боловсруулан ХУД-ын санхүүгийн хэлтэс, ХУД-ын татварын хэлтэст тус тус тайлагнаж ажилласан.

- “Аятакс аудит” ХХК-р 2025 оны санхүүгийн байдлын тайланд аудит хийлгэсэн ба зөрчилгүй дүгнэлт гарсан байна

- Холбогдох үйл ажиллагааны тайлан болон санхүүгийн тайланг аудитын дүгнэлтийн хамт хуульд заасан хугацаанд Санхүүгийн зохицуулах хороо мөн Монголын хөрөнгийн биржид хүргүүлж, цахим хаягт мэдээллийг байршуулсан. Анхаарал тавьсанд баярлалаа.

**Хурлын дарга А.Төмөр-Очир:**

За одоо хурлаар хэлэлцэх асуудлуудаа ярилцъя.

**1. Компанийн 2025 оны жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаархи ТУЗ-ийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэж батлах,**

2025 онд хийсэн ажлын үйл ажиллагааны тайлан болон санхүүгийн тайланг аудитын дүгнэлтийн хамт танилцуулж байна. Хуралд оролцогч хувьцаа эзэмшигчид өмнө нь тараасан мэдээлэлтэй танилцсан байх. Үйл ажиллагааны талаар асуух асуулт, санал хүсэлт байна уу?

**Хувьцаа эзэмшигч Ц.Чанцал:** Санхүүжилтийн асуудлаас болоод төлөвлөсөн ажлууд хэрэгжих боломжгүй болсон байна. Цаашид хөрөнгө оруулалт татах ажлыг илүү өргөн цар хүрээтэй, нарийн судалмаар байна. Дан ганц банк гэлтгүй гадаад дотоодын хөрөнгө оруулагчдад танилцуулж, санхүүжилт татах асуудлыг эрчимжүүлэх шаардлагатай байгаа онцлон хэлье.

**Хурлын дарга А.Төмөр-Очир:** За саяны яригдсан зүйлүүдтэй холбоотой өөр асуух асуулт байна уу?

**Хувьцаа эзэмшигч Ц.Ганцэцэг:** Байхгүй

**Хурлын дарга А.Төмөр-Очир:** За асуух асуулт байхгүй бол компанийн 2025 оны жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаархи ТУЗ-ийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэж батлах уу?

**Хувьцаа эзэмшигч, гүйцэтгэх захирал Ц.Ганцэцэг:** Зөвшөөрч байна.

**Хувьцаа эзэмшигч Ц.Чанцал:** Зөвшөөрч байна. Үйл ажиллагааны тайлангийн талаар Төлөөлөн удирдах зөвлөлөөс гаргасан Дүгнэлтийг баталъя гэв.

**2. Компанийн 2026 оны үйл ажиллагааны болон бизнес төлөвлөгөөг батлах**

Компанийн үйл ажиллагаа зогссон байгаа тул 2026 оны ерөнхий төлөвлөгөөг боловсруулсан. Нарийвчилсан төлөвлөгөө боловсруулах боломжгүй байна. Үүнд:

- Удирдлага зохион байгуулалт – 5 ажил
- Үндсэн үйл ажиллагааны чиглэл – 4 ажил
- Хүний нөөцийн хөгжилийн чиглэл – 3 ажил
- Аж ахуйн чиглэл – 4 ажил
- Санхүүгийн чиглэл – 1 ажил тус тус төлөвлөсөнг танилцуулав.

**Хувьцаа эзэмшигч Ц.Чанцал:** Төлөвлөгөөтэй холбоотой хэдэн зүйл хэлмээр байна. Орчны цэвэрлэгээ хангалтгүй санагдаж байна. Цэвэрлэгээг илүү сайн хийлгэмээр байна. Энэ талаар өмнөх жилийн хурлаар бас хэлж л байсан. Нийт хашааны талбайн цэвэрлэгээг хийлгэж, өнжсөн шар өвсийг хүн хүч гаргаж хадуулах ажил зохион байгуулмаар байна. Мөн төлөвлөгөөнд дурдсан камержуулалтын асуудалд анхаарч ажилламаар байна.

**Хувьцаа эзэмшигч, гүйцэтгэх захирал Ц.Ганцэцэг:** 2026 оны төлөвлөгөөнд тусгагдсан холбогдох арга хэмжээнүүдийг авч ажиллана.

**Хурлын дарга А.Төмөр-Очир:** За өөр асуух асуулт байна уу? Байхгүй бол 2026 оны төлөвлөгөөгөө батлах уу?

**Хувьцаа эзэмшигч, гүйцэтгэх захирал Ц.Ганцэцэг:** Тэгье.

**Хувьцаа эзэмшигч Ц.Чанцал:** Зөвшөөрч байна. Компанийн 2026 оны төлөвлөгөөг баталъя гэв.

**3. Их хэмжээний хэлцэл хийх, хувьцаа нэмж гаргах асуудлыг шийдвэрлэж ТУЗ-д эрх олгох эсэх**

Яагаад шинээр нэмж хувьцаа гаргах гээд байгаа вэ гэхээр өмнөх жилийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал дээр ярьж байсанчлан компанийн үйл ажиллагааг өргөжүүлбэ, шинэ технологи нэвтрүүлэхэд санхүүгийн эх үүсвэр бий болгох зорилгоор нийт зарласан энгийн хувьцааны 10 хүртэлх хувьтай тэнцэх хэмжээний энгийн хувьцааг 2026 ондоо багтаан нэмж гаргасугай гэсэн төсөл боловсруулсаныг юу гэж бодож байна. Хувьцаа эзэмшигч та бүхэн саналаа хэлнэ үү.

**Хувьцаа эзэмшигч Ц.Чанцал:** Нэмж хувьцаа гаргалаа гэхэд одоо үйл ажиллагаа зогссон байгаа тул орж ирж байгаа хувьцааны хөрөнгөөр үйл ажиллагаагаа бүтэн сэргээж чадахгүй. Хувьцаа гаргахаас гадна их хэмжээний хэлцэл буюу хөрөнгө оруулагчтай болох нь зүйтэй байх. Их хэмжээний хэлцэл хийх эрхийг ТУЗ-д олгоё гэсэн саналтай байна.

**Хувьцаа эзэмшигч, гүйцэтгэх захирал Ц.Ганцэцэг:** Тэр нь зөв байх би бас их хэлцэл хийх эрхийг ТУЗ-д олгох нь зүйтэй гэж үзэж байна.

**Хурлын дарга А.Төмөр-Очир:** За тэгвэл нэмж хувьцаа гаргах болон их хэмжээний хэлцэл хийх эрхийг ТУЗ-д олгоё гэж шийдвэр гаргах уу?

**Хувьцаа эзэмшигч, гүйцэтгэх захирал Ц.Ганцэцэг:** Зөвшөөрч байна.

**Хувьцаа эзэмшигч Ц.Чанцал:** Зөвшөөрч байна.

#### **4. ТУЗ-ийн ногдол ашиг тараах эсэх талаар гаргасан тогтоолыг хэлэлцэж батлах**

**Хувьцаа эзэмшигч, гүйцэтгэх захирал Ц.Ганцэцэг:** МУ-ын Компанийн тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.5 дахь хэсэгг "Төлөөлөн удирдах зөвлөл нь санхүүгийн жил дууссанаас хойш 50 хоногийн дотор ногдол ашиг хуваарилах эсэх талаар хэлэлцэн шийдвэрлэсэн байна." гэж заасан байдаг бөгөөд манай "Бөхөг" ХК-ийн Төлөөлөн Удирдах зөвлөлийн 2026 оны 03-р сарын 17-ны өдрийн хурлаас "Бөхөг" Хувьцаат компанийг дахин хөрөнгөжүүлэх асуудал шийдвэрлэх боломжгүй байдлаас болж үйл ажиллагааны үндсэн чиглэл болсон

-шувууны аж ахуй эрхлэх,

-шувууны мах, өндөг бэлтгэх, борлуулах үйл ажиллагаа бүрэн зогссон. Үүнтэй холбоотойгоор орлого орохгүй болж ямар ч санхүүжилтгүй болсон, холбооны антенн байршуулан сайтын түрээсээс олсон орлого нь харуулын цалин, холбогдох нийгмийн даатгал, ХХОАТ төлөхөд зарцуулагдаж байгаа, мөн бусдад төлөх их хэмжээний татварын, зээлийн болон бусад өр төлбөртэй байгаагаас шалтгаалан хувьцаа эзэмшигчдэд ногдол ашиг хуваарилах боломжгүй болохыг нийт хувьцаа эзэмшигчдэд мэдэгдсүгэй." гэсэн №02 тоот Тогтоол гарсан. Энэхүү шийдвэртэй холбогдуулан санхүүгийн тайлан болон бусад шаардлагатай баримт, материалуудыг Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд тайлагнахаар авчирсан байгаатай танилцана уу.

**Хувьцаа эзэмшигч Ц.Чанцал:** Үйл ажиллагаа явуулаагүй тул ногдол ашиг тараахгүй байх нь зүйтэй тул ТУЗ-ийн тогтоолыг баталъя.

**Хувьцаа эзэмшигч, гүйцэтгэх захирал Ц.Ганцэцэг:** Зөвшөөрч байна.

**Хурлын дарга А.Төмөр-Очир:** Хувьцаа эзэмшигчдийн саналыг авлаа, хэлэлцэх асуудал дууслаа. Хурлаар шийдвэрлэсэн асуудал тус бүрээр саналын тоог **ТООЛЛОГЫН КОМИСС** нэгтгэж, шийдвэрийг дүгнэвэл:

**Нэгдүгээр асуудал:**

1. “Бөхөг” Хувьцаат компанийн 2025 оны жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаар Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс оруулсан дүгнэлтийг хэлэлцээд тус компани өнгөрсөн онд үйл ажиллагааг эхлүүлэх санхүүжилтийн асуудлыг шийдвэрлэхээр төсөл боловсруулан, техник технологийн шинэчлэлийн судалгааг хийж, бусдад төлөх өр төлбөрийг төлөх талаар тодорхой ажлуудыг төлөвлөн, амжилттай хэрэгжүүлж ажилласныг тэмдэглэж “Бөхөг” Хувьцаат компанийн 2025 оны жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс өгсөн дүгнэлтийг баталсугай.

**Хоёрдугаар асуудал:**

1. Компанийн 2025 оны үйл ажиллагааны болон бизнес төлөвлөгөөг **Хавсралт №1**–оор баталсугай;

2. Энэ тогтоол, тогтоолын хавсралтаар баталсан бизнес төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах ажлыг Гүйцэтгэх захирал /Ц.Ганцэцэг/-д, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлд үүрэг болгосугай.

**Гуравдугаар асуудал:**

1. Компанийн үйл ажиллагааг өргөжүүлэх, шинэ технологи нэвтрүүлэхтэй холбоотой санхүүхийн эх үүсвэрийг бий болгох зорилгоор компанийн нийт зарласан энгийн хувьцааны 10 хүртэлх хувьтай тэнцэх хэмжээний энгийн хувьцааг 2026 онд багтаан нэмж гаргасугай.

2. Компаниас шинээр хувьцаа гаргахтай холбоотой журмыг **Хавсралт №2**-т зааснаар баталсугай.

3. Шинээр хувьцаа нэмж гаргахтай холбоотой ажлыг эрхлэн гүйцэтгэх, хяналт тавьж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөл, Гүйцэтгэх захирал /Ц.Ганцэцэг/-т тус тус хариуцуулан даалгасугай.

4. Шинээр гаргаж байгаа хувьцаа, түүнтэй холбогдох бүртгэл, Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын шийдвэрийг хэрэгжүүлж, зохих бичиг баримтыг “Санхүүгийн зохицуулах хороо”, “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК болон бусад холбогдох газруудад хуульд заасан хугацаанд, зохих журмын дагуу бүртгүүлэх, хүргүүлэхийг Гүйцэтгэх захирал /Ц.Ганцэцэг/-д үүрэг болгосугай.

**Дөрөвдүгээр асуудал:**

1. “Бөхөг” Хувьцаат компанийн 2025 оны 4 дүгээр улирлын санхүүгийн тайланг судлан үзсэний үндсэн дээр Ногдол ашиг хуваарилахгүй байхаар шийдвэрлэсэн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2026 оны 03-р сарын 17-ны өдрийн №02 тоот тогтоолыг баталсугай.

За хурал үүгээр дуусч байна. Хурлын үйл ажиллагаанд идэвхитэй оролцсон та бүхэндээ баярлалаа.

Хурал удирдсан:  А.Төмөр-Очир/

Хурлын тэмдэглэл хөтөлсөн:

/Ж.Энхбат/

